



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ ДОР-НАГ/2017/01-НА



Зээл, зээлийн хүүгийн 40 хувь буюу
1,4 тэрбум төгрөгийн хугацаа хэтрэлттэй байна.

Чойбалсан хот
2017 он

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймаг дахь Төрийн
аудитын газрын Нийцлийн
аудитын алба

Дарга, Тэргүүлэх аудитор
Б.Болортуул
Утас: 70584203

Аудитын менежерийн
үүргийг түр орлон
гүйцэтгэгч Д.Нармандах
Утас: 70584207

Ахлах шинжээч
Ж.Баяртуул
Утас: 70584207

Шинжээч
С.Энхбаатар
Утас: 70584207

2017 оны 06 дугаар
сарын 15

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70584207 дугаарын
утас, 70584203
дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,
Хэрлэн сум, 7-р баг,
аймгийн ЗДТГ-ын 2-р
байр, 2 давхар 04 тоот

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

I Бүлэг. СХС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасан нэр төрлийн дагуу төлөвлөж бүрдүүлээгүй байна.

1.1. Сумдууд нь төсвийн эх үүсвэрт СХС-гийн хөрөнгийг огт тусгаагүй байна.

1.2. Сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд анхаарч ажиллаагүй, зөвхөн нэг нэр төрлийн эх үүсвэрээс бүрдүүлсэн байна.

II Бүлэг: Сумын хэтийн төлөвлөгөөтэй уялдуулан СХС-гаас зээл олгоогүй нь зээл хугацаандаа төлөгдөхгүйд хүргэсэн байна.

2.1. Сумын хэтийн төлөвлөгөөтэй уялдуулан СХС-гаас зээл олгоогүй нь зээл хугацаандаа төлөгдөхгүй, чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэхэд хүргэсэн байна.

2.2. СХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл сонгон шалгаруулахдаа эдийн засгийн тооцоо, судалгаагүй төслийг шалгаруулсан байна.

III Бүлэг: Сангийн үйл ажиллагаанд хяналт тавиагүйгээс журам зөрчигдөх, хугацаандаа төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн зээлийн авлага өссөн байна.

3.1. Сангийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байна.

3.2. Нийт төлөгдөх зээлийн 40,6 хувийг хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүү эзэлж, сангийн дансанд төвлөрүүлэх зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.

3.3. Сангийн мэдээ тайланг олон нийтэд мэдээлсэн байна.

ДҮГНЭЛТ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН ХАРИУ

ЗӨВЛӨМЖ

АЛБАН ШААРДЛАГА

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
МУ	Монгол Улс
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НАГ	Нийцлийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
ДОР	Дорнод
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
СХС	Сум хөгжүүлэх сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, бэрхшээл**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Дорнод аймаг дахь Төрийн Аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

СХС-гийн 2014-2016 онуудын хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдал хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт өгч, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан холбогдох албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудитыг хийж гүйцэтгэлээ.

1. СХС-гийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлсэн эсэх.
2. СХС-гийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу зарцуулсан эсэх.
3. СХС-гийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, олон нийтэд мэдээлсэн эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитад төсвийн Ерөнхийлөн захирагч, сумдын ИТХ, Засаг дарга, сумдын санхүү албаны дарга, мэргэжилтэн, ЖДҮ-ийн мэргэжилтэн, эрх бүхий холбогдох албан тушаалтан, иргэн, аж ахуйн нэгжүүдийг хамруулан тэдгээрийн 2014-2016 онуудын ажлын тайлан, статистик мэдээ, судалгаа, бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.

Үндсэн мэдээлэл

“Сум хөгжүүлэх сан” гэж сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, сэргээх болон шинээр ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгоход зориулагдсан хөрөнгийг хэлнэ” гэж МУ-ын ЗГ-ын 2011 оны 134, 2016 оны 153 дугаар тогтоолуудад заасан байна.

МУ-ын ЗГ-ын 2011 оны 134, 2016 оны 153 дугаар тогтоолуудаар “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам, гэрээний загвар”-ыг баталсан байна.

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 2014 онд 2011-2013 оны СХС-гийн хөрөнгийн бүрдүүлэлт зарцуулалтад нийцлийн аудитыг гүйцэтгэж байсан.

Дорнод аймагт СХС-д 2011-2016 онуудад орон нутгийн төсвөөс нийт 5,9 тэрбум төгрөгийг шилжүүлж, зээл болон зээлийн хүүгийн эргэн төлөлтөөр нийт 956 төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэн 1'562 иргэнийг ажлын байраар хангасан байна.

Мөн СХС-д 2014-2016 онуудад улсын төсвөөс нийт 870,7 сая төгрөг шилжүүлэхээр төлөвлөсөн боловч 22,5 хувийг буюу 196,7 сая төгрөгийг шилжүүлж,

зээл болон зээлийн хүүгийн эргэн төлөлтөөр нийт 122 төсөл хөтөлбөрийг 1'036,7 сая төгрөгөөр санхүүжүүлэн 273 иргэнийг ажлын байраар хангасан байна.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100-400, 4000, 4200, төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, цуглуулсан судалгааны баримт материалд дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу шаардлагатай нотлох зүйлсийг цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын 2011 оны 134 дүгээр “СХС-гийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам, гэрээний загвар батлах тухай” тогтоол
- Засгийн газрын 2016 оны 153 дугаар “СХС-гийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам, гэрээний загвар батлах тухай” тогтоол
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нармандах үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, нийцлийн аудитын албаны ахлах шинжээч Ж.Баяртуул, шинжээч С.Энхбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа

Аудитыг 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхэлж, 05 дугаар сарын 26-ны өдөр дуусган дарга, Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж, тайланг 06 дугаар сарын 02-ны дотор холбогдох албан тушаалтанд хүргүүллээ.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын хариу, албан шаардлага, аудитын зөвлөмж хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 3 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай, зохистой хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгадагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажууллаа.

I Бүлэг. СХС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасан нэр төрлийн дагуу төлөвлөж бүрдүүлээгүй байна.

1.1 СХС-гийн эх үүсвэрийг журамд заасан нэр төрөл тус бүрээр бодитой төлөвлөөгүй байна.

СХС-гийн үйл ажиллагаа нь Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль болон Засгийн газрын 2011 оны 134, 2016 оны 153 дугаар тогтоолуудаар баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмаар зохицуулагдаж байна.

Засгийн газрын 2011 оны 134, 2016 оны 153 дугаар тогтоолуудын 2 дугаар бүлэгт дараах эх үүсвэрүүдээс бүрдүүлэхээр заажээ. Үүнд:

- 2.1.1-д “Улсын төсвөөс олгох сангийн эргэлтийн хөрөнгө”,
- 2.1.2-д “Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдийн хандив, тусламж”,
- 2.1.3-д “Сангаас олгосон зээлийн хүүгийн орлого”,
- 2.1.4-д “Хугацаандаа төлөгдөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги”.

Харин сумдын ИТХ-аар “сумын төсвийг батлах”-даа СХС-гийн хөрөнгийн эргэн төлөгдөх хуваарийн дагуу төлөгдөлт, төсвийн орлогын нэг хэсэг болоход анхаараагүй, тухайн жилийн төсвийн орлогыг төлөвлөхдөө нийт олгосон зээлээс хуваарийн дагуу төлвөл зохих нийт зээлийн хэмжээний судалгаа, тооцоо байхгүйгээс тухайн жилүүдэд СХС-д төвлөрүүлэх эх үүсвэрийг огт тооцож төлөвлөөгүй байна.

1.2 Сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд анхаарч ажиллаагүй зөвхөн нэг нэр төрлийн эх үүсвэрээс бүрдүүлсэн байна.

Жижиг дунд бизнесд зориулан нийт 5,9 тэрбум төгрөгийн орлогыг зөвхөн СХС-гийн журмын 2.1.1-д “Сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн орлого”-оос төвлөрүүлсэн байна.

Харин Сум хөгжлийн сангийн Засгийн газрын 2011 оны 134 дугаар тушаал, 2016 оны 153 дугаар тогтоолуудын 2 дугаар бүлэгт заасан бусад 3 төрлийн дараах эх үүсвэрүүдээс огт бүрдүүлээгүй байна.

- 2.1.1-д “Улсын төсвөөс олгох сангийн эргэлтийн хөрөнгө”,
- 2.1.2-д “Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдийн хандив, тусламж”,
- 2.1.3-д “Сангаас олгосон зээлийн хүүгийн орлого”
- 2.1.4-д “Хугацаандаа төлөгдөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги”.

II Бүлэг. Сумын хэтийн төлөвлөгөөтэй уялдуулан СХС-гаас зээл олгоогүй нь зээл хугацаандаа төлөгдөхгүйд хүргэсэн байна.

2.1 Сумын хэтийн төлөвлөгөөтэй уялдуулан СХС-гаас зээл олгоогүй нь зээл хугацаандаа төлөгдөхгүй, чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэхэд хүргэсэн байна.

Төрийн сангийн дансаар дамжуулан суманд үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих, тэдэнд бага хүүтэй банкны шаардлагаас гадуур зээл олгох, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор СХС-гийн хөрөнгийн эх

үүсвэрээс сумын иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээлийг олгосон болно.

СХС-гийн хөрөнгөөр төсөл сонгон шалгаруулалтыг Засгийн газрын 2011 оны 134, 2016 оны 153 дугаар тогтоолуудаар баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмын 4.3-д зээл олгох төслийн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон байна. Үүнд:

- 4.3.1-д “тухайн суманд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх”
- 4.3.2-д “төслийн хүрэх үр дүн, зорилт тодорхой байх”
- 4.3.3-д “гэрээний хугацаанд зээлийг эргэн төлөх боломжтой байх”
- 4.3.4-д “төслийн зээлийн мөнгөн дүнд хүрэлцэхүйц барьцаа хөрөнгөтэй байх”
- 4.3.5-д “төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг бодитой тодорхойлсон, даван туулах арга замыг тусгасан байх”

Сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл, төлөвлөгөөний дагуу сумандаа жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилгод нийцүүлэн ямар салбарт эрэлт хэрэгцээ байгааг нарийвчлан судлаагүй, сумын хэмжээнд төсөл сонгон шалгаруулахад иргэдийн оролцоог хангаагүйгээс сайн төслийг сонгон шалгаруулж чадахгүй байна.

Сумдын СХС-гаас олгосон зээлийг үйл ажиллагааны чиглэлээр харуулбал:

/Хүснэгт 1/

№	Сумдын нэрс	Дэмжигдсэн төслийн тоо /үйл ажиллагааны чиглэл/							Нийт
		Хүнсний үйлдвэрлэл	Хөнгөн үйлдвэрлэл	Газар тариалан	Мал аж ахуй	Барилга	Худалдаа үйлчилгээ	Бусад ¹	
1	Баяндун	10	7	2	5	1	0	11	36
2	Баянтүмэн	8	3	7	15	4	2	13	44
3	Баян-Уул	9	9	2	3	2	2	5	40
4	Булган	3	13	2	14	8	11	5	56
5	Гурванзагал	6	0	12	8	5	2	33	66
6	Дашбалбар	5	14	6	11	0	2	0	38
7	Матад	10	8	8	2	6	13	3	50
8	Сэргэлэн	6	15	0	6	0	10	0	37
9	Халхгол	20	7	6	7	0	17	1	58
10	Хөлөнбуйр	39	18	7	14	9	13	27	127
11	Хэрлэн	41	22	16	31	19	11	42	182
12	Цагаан-Овоо	13	4	4	8	2	0	56	87
13	Чойбалсан	4	6	2	14	2	3	10	41
14	Чулуунхороот	5	14	6	13	0	8	38	84
	Нийт	179	140	80	151	58	104	244	946

Хүснэгтээс харахад олгосон зээлийн 18,9 хувийг хүнсний үйлдвэрлэл, 14,7 хувийг хөнгөн үйлдвэрлэл, 8,4 хувийг газар тариалан, 15,9 хувийг мал аж ахуй, 6,2 хувийг барилга, 10,9 хувийг худалдаа нийт 6 чиглэлд олгосон зээлийн 75,9 хувь буюу 702 төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлсэн байна.

Харин төсөл хөтөлбөрийг бусад төрлөөр төрөлжүүлэн олгосон СХС-гийн зээлийн эргэн төлөгдөлтийн хэмжээ нь хэвийн хэмжээтэй байна.

Сумд нь СХС-гаас зээл олгохдоо ижил төстэй, үйл ажиллагааны чиглэл давхацсан олон төсөл хөтөлбөрт зээлийг олгосноор тухайн салбарын нийлүүлэлт

¹ Бусад: Зочид буудал, авто, мотоцикл, дугуй засвар, модон эдлэл, мал нядалгаа, бог малын хээлтүүлэг, интэрнет кафе, канон, дайман хүлэмж хийх, бичил лаборатор гэх мэт

хэтэрч зээлдэгчдийн зээл хугацаандаа төлөгдөөгүй байна.

Нийт олгосон зээлээс хугацаа хэтрэлттэй зээлийг харуулбал:

/сая.төгрөг/

/Хүснэгт 2/


№	Сумдын нэрс	Олгосон зээлийн судалгаа		
		Нийт олгосон зээл	Хугацаа хэтрэлттэй зээл	Эзлэх хэмжээ
1	Баяндун	261,3	129,5	47,6
2	Баянтүмэн	228,0	78,3	34,3
3	Баян-Уул	344,1	98,5	28,4
4	Булган	337,0	26,8	7,0
5	Гурванзагал	297,8	65,9	17,6
6	Дашбалбар	372,8	85,5	22,9
7	Матад	272,6	98,1	34,8
8	Сэргэлэн	299,8	49,4	16,4
9	Халхгол	484,5	19,2	3,6
10	Хөлөнбуйр	409,2	25,7	5,3
11	Хэрлэн	1'732,9	478,2	26,7
12	Цагаан-Овоо	381,5	118,8	28,5
13	Чойбалсан	258,7	55,6	19,5
14	Чулуунхороот	308,4	89,3	27,0
	Нийт	5'988,4	1'418,8	23,6

Аймгийн хэмжээнд 2011-2016 онуудад СХС-гийн хөрөнгөөс нийт 956 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,9 тэрбум төгрөгийн зээлийг жилд 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай олгосноор шинээр байнгын ажлын байр 981, түр ажлын байр 581 бий болсон байна.

Сангаас олгосон зээлээр 2011-2013 онд 601, 2014-2016 онуудад 388 шинэ болон хуучин ажлын байрыг тус тус нэмэгдүүлсэн байна.

Сумдын олгосон зээлээр ажлын байр нэмэгдүүлсэн байдлыг салбар тус бүрээр:

/график 1/



Сангаас олгосон зээлээр 2014-2016 онуудад хүнсний үйлдвэрлэлд 66, хөнгөн үйлдвэрлэлд 65, газар тариаланд 35, мал аж ахуйд 68, худалдаа, үйлчилгээнд 24, барилгын материал үйлдвэрлэлд 38, бусад 102 ажлын байр тус тус нэмэгдүүлсэн байна. Харин 2014-2016 онд өмнөх онуудтай харьцуулахад 200 ажлын байраар буурсан. Энэ нь хугацаандаа төлөгдөөгүй, чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдсэнээс дахин нэмж зээл олгоогүйтэй холбоотой байна.

2.2 СХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл сонгон шалгаруулахдаа эдийн засгийн тооцоо, судалгаагүй төслийг шалгаруулсан байна.

СХС-гийн хөрөнгөөр төсөл сонгон шалгаруулалтыг Засгийн газрын 2011 оны 134, 2016 оны 153 дугаар тогтоолуудаар баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг үндэслэл болгон СХС-гийн төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь иргэдээс ирүүлсэн төслийн сонгон шалгаруулалтыг жилд 1-2 удаа шалгаруулсан байна.

Сумдын СХС-гаас төсөл сонгон шалгаруулалтаар олгосон зээл:

Сумдын нэрс		2014 онд олгосон зээл	2015 онд олгосон зээл	2016 онд олгосон зээл	Нийт
№					
1	Баяндун	50,0	0	0	50,0
2	Баянтүмэн	50,0	49,0	33,0	132,0
3	Баян-Уул	47,5	70,0	0	117,5
4	Булган	49,0	0	0	49,0
5	Гурванзагал	39,0	58,0	0	97,0
6	Дашбалбар	83,0	48,5	0	131,5
7	Матад	48,0	36,6	0	84,6
8	Сэргэлэн	35,0	71,0	0	106,0
9	Халхгол	96,0	84,2	55,0	235,2
10	Хөлөнбуйр	53,0	48,5	71,0	172,5
11	Хэрлэн	314,3	255,5	104,0	673,8
12	Цагаан-Овоо	53,0	39,1	17,5	109,6
13	Чойбалсан	53,0	0	0	53,0
14	Чулуунхороот	80,0	51,0	20,0	151,0
Нийт		1'050.8	811.4	300.5	2'162.7

/Хүснэгт 3/

Гэвч төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь зээл олгохдоо Засгийн газрын 2011 оны 134, 2016 оны 153 дугаар тогтоолуудаар баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмын 4.2.2², 4.2.3³-д заасан шалгуур хангасан зээлдэгчидэд олгоогүй байна.

Матад, Баяндун, Цагаан-Овоо сумдууд нь зээлдэгчидтэй зээлийн гэрээ байгуулахдаа Засгийн газрын 2011 оны 134, 2016 оны 153 дугаар тогтоолуудаар баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмын 2 дугаар хавсралтад заасан нөхцлийн дагуу хугацаа хэтэрсэн зээлд алданги тооцох хувь хэмжээг зааж өгөөгүй байна.

Мөн Сангийн үйл ажиллагаа хариуцсан албан тушаалтанууд зээлийг эргэн төлүүлэх талаар арга хэмжээ зохион байгуулаагүй, ашиглалтын явцад хяналт тавьж ажиллаагүй байна.

III Бүлэг. Сангийн үйл ажиллагаанд хяналт тавиагүйгээс журам зөрчигдөх, хугацаандаа төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн зээлийн авлага өссөн байна.

3.1. Сангийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байна.

Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-д зааснаар сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий 7 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус ажлын хэсэг, сангийн үйл ажиллагаа, зээлийн гэрээний хэрэгжилтэд жилд 2-оос доошгүй удаа шалгалт хийж,

² 4.2.2-д “Сум хөгжүүлэх болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх”

³ 4.2.3-д “Зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай байх”

дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн Хуралдаанаар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлэх үүрэгтэй.

Сумдын ИТХ-ын тогтоолоор байгуулагдсан СХС-гийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсгүүд 2014-2015 онд сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан эсэхийг үзэхэд:

- Баян-Уул, Дашбалбар, Сэргэлэн сумаас бусад сумд СХС-гийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгүүд 2014 онд хяналт тавиагүй,
- Баян-Уул, Дашбалбар, Цагаан-Овоо, Чойбалсан сумаас бусад сумд СХС-гийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгүүд 2015 онд огт хяналт тавьж ажиллаагүй нь Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 5.3 дахь “Энэхүү журмын 3.1.5-д заасан ажлын хэсэг сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, зээлийн гэрээний хэрэгжилтэд тухайн санхүүгийн жилд 2-оос доошгүй удаа шалгалт хийж, дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлж байна.” гэж заасныг огт хэрэгжүүлээгүй байна.

Сангийн үйл ажиллагаанд 2014-2015 онд Баян-Уул, Дашбалбар, Сэргэлэн, Цагаан-Овоо, Чойбалсан зэрэг сумдын орон тооны бус ажлын хэсэг хяналт шалгалт хийсэн боловч ажлын дүнг сумын ИТХ-аар хэлэлцүүлээгүй, зээлийн үр дүн гараагүй, хугацаа хэтэрсэн зээлийн зөрчил арилаагүй байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам” шинэчлэгдэн батлагдсан бөгөөд уг журмын дагуу аймгийн нийт 14 сумын ИТХ 2016 онд сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг шинэчлэн байгуулсан эсэхийг үзэхэд Баяндун, Баянтүмэн, Булган, Гурванзагал, Сэргэлэн, Хэрлэн, Чойбалсан, Чулуунхороот сумаас бусад сумд тухайн онд шинэчлэн байгуулалгүй 2017 оны 1 дүгээр улиралд байгуулсан байна.

Баян-Уул сумаас бусад сумын хяналт тавих зөвлөлүүд 2016 онд сангийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргээ огт хэрэгжүүлээгүй байна.

СХС-гаас 2013 оноос өмнө олгосон, хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийг шүүх хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэн төлүүлэх ажлыг ихэнх сумд зохион байгуулсан байна.

Сумдын орон тооны бус хяналтын зөвлөлүүд сангийн үйл ажиллагаанд журмын дагуу хяналт тавиагүйгээс зээлийн үр дүн буурах, хугацаа хэтэрсэн зээл өсөх нөхцөл бүрдсэн байна.

Аймгийн санхүүгийн хяналт, аудитын албанаас Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах хяналт тавих журам”-ын хэрэгжилтэд 2015 онд нийт сумдыг хамруулан, 2016 онд 5 сумыг хамруулан хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар хугацаандаа төлөөгүй хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн 563.6 сая төгрөгийн зөрчилд 34 акт тогтоож, 15 албан шаардлага өгч ажилласан боловч хэрэгжилт нь хангалтгүй байна.

Иймд СХС-гийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэн ажиллуулж, чанаргүй зээлийн асуудлыг үе шаттай зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

3.2. Нийт төлөгдөх зээлийн 40,6 хувийг хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүү эзэлж байна.


Сумдын сум хөгжүүлэх сангууд 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт 3.2 тэрбум төгрөгийн авлага тайлагнасан бөгөөд үүнээс хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлага 1.4 тэрбум төгрөг байна.

Сумдууд сангаас олгож байгаа зээлийн үндсэн төлбөр, зээлийн хүүг гэрээнд заасан графикайн дагуу сангийн дансанд бүрэн төвлөрүүлээгүй нь Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмын 3.2.4⁴-д заасныг зөрчиж байна.

Мөн сангийн 2013 оноос өмнө зээлд хамрагдсан 289 иргэн, аж ахуйн нэгж 2016 оны жилийн эцсийн байдлаар зээлийн гэрээнд заасан хугацаанд зээлийн үндсэн төлбөр, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн үлдэгдэлтэй байгаа нь дээрх журмын 4.7⁵ дахь заалттай нийцэхгүй байна.

Хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлагыг сумдаар үзүүлвэл:

/график 2/



Дээрх графикаас үзэхэд бүх сумд хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлагатай байна. Сангаас олгосон зээлийн эргэн төлөлт хангалтгүй, гэрээний хугацаа хэтэрсэн хоног тутамд алданги торгууль тооцох заалтыг Баян-Уул, Матад, Сэргэлэн, Чулуунхороот сумаас бусад сумд хэрэгжүүлээгүй байна.


Аудитын явцад сумдаар газар дээр нь очиж арга зүйн зөвлөгөө өгч ажиллан СХС-гийн зээлдэгчид болон дараа дараагийн зээл хүсэгч иргэдтэй уулзаж тус

⁴ “эргэн төлөгдсөн зээл, хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх”

⁵ “Иргэн, аж ахуйн нэгж олгосон зээлийн хөрөнгө, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд Сум хөгжүүлэх сангийн дансанд эргэн төлнө.”

сангийн үйл ажиллагааны талаарх эрх зүйн орчныг таниулснаар 14 сумдын зээлдэгчдээс хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүү 49,1 сая төгрөг, хуваарийн дагуу 156,6 сая төгрөг нийт 205,7 сая төгрөгийг барагдуулан ажилласан.

График 3/



Сум тус бүрээр гэрээнд заасны дагуу төлөөгүй хугацаа хэтрүүлсэн зээл, зээлийн хүүгийн дүнг хувиар тооцож харьцуулахад Хэрлэн сум 34 хувь, Баяндун сум 9 хувь, Цагаан-Овоо сум 8 хувийг тус тус эзэлж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

Сангаас олгосон зээлийн хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ их, эргэн төлөлт хангалтгүй байгаа нь сангийн орон тооны бус хяналтын зөвлөл Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 5.3⁶-д заасныг хэрэгжүүлэн ажиллаагүйтэй холбоотой байна.

Баяндун, Булган, Матад, Халхгол сумд Сангаас олгогдож байгаа зээлийн эргэн төлөх хугацаа хэтэрсэн зээлдэгч нарыг гэрээнд заасны дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх ажлыг зохион байгуулаагүй нь гэрээний хариуцлагыг сулруулах нөхцөл байдлыг бүрдүүлсэн байна.

Харин дээрх сумдаас бусад 10 сум хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн 473.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа 103 иргэн аж ахуйн нэгжийн материалыг бүрдүүлж шүүхэд шилжүүлсэн байна.

Иймд хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлагыг барагдуулах талаар үе шаттай арга хэмжээг зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

⁶ “Энхүү журмын 3.1.5-д заасан ажлын хэсэг сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, зээлийн гэрээний хэрэгжилтэд тухайн санхүүгийн жилд 2-оос доошгүй удаа хяналт шалгалт хийж, дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлж байна.”

3.3. Сангийн мэдээ тайланг олон нийтэд мэдээлсэн байна.

Аудитын явцад сум хөгжүүлэх сангийн зарцуулалтын талаарх мэдээллийг ил тод мэдээлж буй эсэхийг үзэхэд сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөл болон хяналтын зөвлөлийг байгуулсан тогтоол шийдвэр, сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг танилцуулсан зурагт хуудас, мэдээ судалгааг гаргаж байгууллагын мэдээллийн самбартаа байршуулсан байна. Мөн сантай холбоотой мэдээ мэдээллийг ИТХ болон багийн хуралд танилцуулдаг байна.

Аудитаар нийт 1,4 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,4 тэрбум төгрөгийн 1 албан шаардлага, 6 зөвлөмж өгч ажиллалаа.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Сумын төсөвт зээл, зээлийн хүүгийн төлбөрийг орлогоор огт тусгаагүй байна.
2. Сумдууд нь СХС-г нэг эх үүсвэрээс бүрдүүлсэн байна.
3. СХС-гаас зээл олгохдоо сумын хэтийн төлөвлөгөөтэй уялдуулаагүй байна.
4. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл сонгон шалгаруулахдаа эдийн засгийн тооцоо, судалгаагүй төслийг шалгаруулсан байна.
5. Сангийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байна.
6. Зээлийн гэрээг байгуулахдаа алдангийн хувь хэмжээг гэрээнд тусгаж өгөөгүй байна.
7. Сангийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүйгээс хугацаандаа төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлага өссөн.
8. Сангаас олгосон зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг журамд заасны дагуу бүрэн төвлөрүүлээгүй байна.
9. Нийт төлөгдөх зээлийн 40 хувийг хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүү эзэлж байна.
10. Өмнөх онд санхүүгийн хяналт, аудитын албанаас тавьсан акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 48 хувьтай байна.
11. СХС-гийн мэдээ тайланг олон нийтэд мэдээлсэн байна.

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын тайлбар

“СХС-гийн зарцуулалт”-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төслийг 2017 оны 06 дугаар сарын 13-ны өдөр аймгийн Засаг даргад хүргүүлсэн гэвч одоог хүртэл тайлангийн хариу ирүүлээгүй боловч аудитаар илэрсэн 1,4 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн алдангийн зөрчлийг хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэл, албан шаардлагын хяналтын хуудсанд хүлээн зөвшөөрч гарын үсгээр баталгаажуулсан болно.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1⁷-д заасны дагуу аудитын тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажууллаа.

⁷ Аудит хийлгэсэн байгууллагад тайлангийн төслийг өгч ажлын 10 хоногийн дотор саналаа өгөхийг хүсэх;

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

1. Өмнөх онд санхүүгийн хяналт, аудитын албанаас тавьсан акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулах чиглэл өгч ажиллах.

Сумдын ИТХ-ын дарга нарт:

1. Сангийн орон тооны бус хяналтын зөвлөлийг журмын дагуу хяналт шалгалт хийлгэж, дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж байх.

Сумдын Засаг дарга нарт:

1. СХС-гийн орлогыг журамд заасан нэр төрөл тус бүрээр тооцож төлөвлөх.
2. Сумдууд нь зээл олгохдоо сумын хөгжлийн хэтийн төлөвлөгөөтэй уялдуулах, тооцоо судалгаанд үндэслэн өөрийн онцлогийг харгалзан үнэн зөв тодорхойлох.
3. Зээлийн гэрээг байгуулахдаа алдангийн хувь хэмжээг журмын дагуу гэрээнд тусгаж өгөх.
4. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл сонгон шалгаруулахдаа эдийн засгийн тооцоо, судалгааны хяналтыг хийх.
5. Баяндун, Булган, Матад, Халхгол, Хэрлэн, Цагаан-Овоо сумд хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлагыг шүүхэд шилжүүлж, авлагыг барагдуулах талаар онцгой анхаарч ажиллах.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕРИЙН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

АХЛАХ ШИНЖЭЭЧ
ШИНЖЭЭЧ



Б.БОЛОРТУУЛ

Д.НАРМАНДАХ

Ж.БАЯРТУУЛ

С.ЭНХБААТАР

